

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
СҮЛД ЧУУЛГА**

2019.10.04

Улаанбаатар хот

**2019 ОНЫ III УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТАЙЛАН**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн талаар**

Тайлант хугацаанд Сүлд чуулга төрийн хууль тогтоомж, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн “Удирдлагын манлайлал, алба хаагчдын сахилга хариуцлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх” зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, албан даалгавар, үүрэг, чиглэл, ЦБҮАЖ, дүрэм, холбогдох бусад эрх зүйн актуудыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ III улиралд чуулгын хэмжээнд нийт 39 ажил, арга хэмжээг төлөвлөн, гүйцэтгэлийг ханган ажиллалаа.

Дээрх тушаалыг үндэслэн ЦЕГ-ын даргын 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Б/729 дүгээр тушаалаар тус чуулгын дуучин, цагдаагийн ахлах ахлагч Г.Дарханбаатарыг дууны хэсгийн ахлагч, хөгжимчин, цагдаагийн ахлах ахлагч О.Даваадоржийг хөгжмийн хэсгийн ахлагчаар тус тус томилж, цагдаагийн дэслэгч цолыг олгов.

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор чуулгын 20 албан тушаалын тодорхойлолтын төслийг ЦЕГ-ын ТЗБХ-т хүргүүлж, батлуулсан бөгөөд алба хаагч нэг бүрт танилцууллаа.

III улиралд даргын зөвлөлийн хурлыг 5 удаа хийж хүний нөөцтэй холбоотой 15, үйл ажиллагаатай холбоотой 8, нийт 23 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Чуулгын даргын тушаалаар 7 алба хаагч, ажилтныг томилж, 8 алба хаагч, ажилтныг чөлөөлж, 1 алба хаагчид чөлөө олгож, 6 алба хаагчийн цалингийн зэрэглэлийн шатлалыг өөрчлөн тогтоосон.

Бие бүрэлдэхүүний өдөр тутмын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангахтай холбоотойгоор чуулгын даргаас нийт бие бүрэлдэхүүнд 14, офицер бүрэлдэхүүнд 8 удаа үүрэг өгч, дуучид, хөгжимчид, бүжигчдийг тусгайлан хүлээн авч уулзан уран бүтээлийн урын санг баяжуулах, чанар чансааг дээшлүүлэх талаар тус тус 1 удаа үүрэг, чиглэл өгөв.

Тайлант хугацаанд хүний нөөцийн чиглэлээр 27, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 6, нийт 33 тушаал гаргаж, алба хаагч, ажилчдаас 19 өргөдөл хүлээж авснаас ажилд орох, суралцахыг хүссэн 5, захиргааны чөлөө хүссэн 6, бусад 8 өргөдлийг хүлээж авсан байна.

Өргөдөл гомдлын мэдээг энэ оны 24/344 тоот албан бичгээр, сахилгын зөрчлийн мэдээг 24/343 тоот албан бичгээр 09 дүгээр сарын 25-наар тасалбар болгон холбогдох дээд шатны байгууллагуудад хүргүүлэн ажилласан.

Чуулгаас нийт 110 албан бичиг гадагш явуулж, 161 албан бичгийг хүлээн авч, зохих журмаар шийдвэрлэв.

ЦЕГ-ын ТЗБХ-ийн даргад 07 дугаар сарын 01-ны 24/299 дугаартай албан бичгээр 2019 оны эхний хагас жилийн тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж хүргүүлэн, тайлангийн хурлыг хийж, ЦЕГ-ын болон чуулгын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт үр дүнг танилцуулан, эхний хагас жилийн сахилгын зөвлөгөөнийг зохион байгуулсан болно.

Монгол Улсын ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамжаар баталсан “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн ажилд улсын үзлэг явуулах удирдамж”-ийн биелэлтийг хангах ажлын хүрээнд чуулгын даргын 01 тоот албан даалгаврыг баталж хэрэгжилтийг ханган, улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг чуулгын даргын тушаалаар томилж, нэгж тус бүрийг улсын үзлэгт бэлтгүүлэх ажлыг зохион байгуулан, урьдчилсан үзлэг, тооллогыг байгууллагын хэмжээнд явуулж, салбар комиссын даргын 2019 оны 05 дугаар сарын 16-ны 8/904 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Зөвлөмж, ажлын чиглэл хүргүүлэх” ажлын чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулгыг ЦЕГ-ын Төв архивт хүргүүлсэн.

Баталсан тушаал, хуваарийн дагуу тус чуулгын 6 офицер алба хаагч 07 дугаар сарын 10-наас 15-ныг хүртэлх хугацаанд баталсан хуваарийн дагуу 24 цагаар ерөнхий эргүүлийн үүрэг гүйцэтгэв.

Тулгар төрийн 2228, Их Монгол Улсын 813, Ардын хувьсгалын 98 жилийн ой, Үндэсний Их баяр наадмын өдрүүдийг тохиолдуулан ЦЕГ-ын дарга, дотоодын цэргийн командлагч цагдаагийн хурандаа С.Баатаржаваас цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга захирагч нарт өгсөн үүргийн биелэлтээс чуулгын үйл ажиллагаанд хамаарах 7 заалтын хүрээнд биелэлтийг гаргаж ЦЕГ-ын МДШШУА-нд хүргүүлсэн.

ЦЕГ-ын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/121 дугаар тушаалаар цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй “Эрүүл цагдаа хөтөлбөр”-ийн хүрээнд алба хаагч, ажилтны мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэг хийх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд тус чуулгын 55 алба хаагчийг 7 төрлийн үзлэг шинжилгээнд хамруулав.

2019 оны ээлжийн амралтын хуваарийн дагуу чуулгын 61 алба хаагч ажилтан ээлжийн амралтаа эдэлсэн байна.

Чуулгын уран бүтээлчдийн орон тоог бэхжүүлэх зорилгоор Тээврийн цагдаагийн алба, Дотоодын цэргийн штаб, Өвөрхангай, Завхан аймаг дахь цагдаагийн газарт орон тоо хүссэн албан бичгийг хүргүүлээд байгаагийн дээр бусад алба, нэгжтэй энэ тухай асуудлаар хүсэлт, яриаг үргэлжлүүлж байна.

2019 оны 3 дугаар улирлын соён гэгээрүүлэх ажлын мэдээ, биелэлтийг 24/395 дугаартай албан бичгээр, албаны сургалтын тайланг СГАСХ-т хүргүүлсэн.

Чуулгын нийт офицер албан тушаалтан, алба хаагч, ажилтан нэг бүрээр 3 дугаар улирлын ажлын гүйцэтгэлийг үнэлэн дүнг гаргаж, нэгж тус бүрээр болон чуулгын хэмжээгээр байр эзлүүлэн зарим алба хаагчдыг урамшууллаа.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны Б/502 дугаартай тушаалаар Цагдаагийн албаны төлөө-II зэргийн медалиар 1, Цагдаагийн албаны төлөө-III зэргийн медалиар 2 алба хаагч шагнуулж, мөн даргын 2019 оны Б/501 дугаартай тушаалаар ЦЕГ-ын “Хүндэт жуух”-аар 1, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 3112 дугаартай тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр 1, ЦЕГ-ын даргын 2019 оны Б/737 дугаартай тушаалаар “Хүндэт жуух”-аар 1, БСШУСЯ-ын “Жуух бичиг”-ээр 4 алба хаагч тус тус шагнагдлаа.

### **Хоёр. Сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар**

**Соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:** “Цагдаа, дотоодын цэргийн 2019 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний 2.8-дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мөрдөн байцаах алба, Төмөр зам дахь цагдаагийн газар, Дорноговь аймаг

дахь цагдаагийн газар, Төв аймаг дахь цагдаагийн газар, Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын цагдаагийн хэлтэс зэрэг 5 байгууллагын алба хаагч, тэдний гэр бүл, цагдаагийн байгууллагын ахмад ажилтан, ЕБС, аж ахуй нэгж байгууллагад чиглэсэн “Үргэлж тантай хамтдаа соён гэгээрүүлэх цогц өдөрлөг”-ийг зохион байгуулсан.

Зөвхөн тус өдөрлөгийн хүрээнд 878 алба хаагч, тэдний 29 гэр бүлийн гишүүн, 2 аж ахуйн нэгж, байгууллага, 78 иргэн, ерөнхий боловсролын 8 сургуулийн 830 сурагч, нийт 2489 хүнд хүрч ажилласан байна.

Түүнчлэн түүхт ой нь тохиосон Эрүүгийн цагдаагийн алба, Дотоодын цэргийн 05 дугаар анги, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын төвийн Эрэлч нохойн алба, Дорноговь аймаг дахь цагдаагийн газар, Дорноговь аймгийн Алтанширээ сум, Өвөрхангай, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газруудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ойн баяраар орон нутгийн иргэд, зочид төлөөлөгчид, алба хаагчид өндөр үнэлгээ өгсөн, тэдний сэтгэлд нийцсэн урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулж, зөвхөн ойн баярын хүрээнд урлаг соёлын үйлчилгээг 15750 гаруй хүнд хүргэжээ.

Өвөрхангай аймгийн 82 иргэнээс авсан санал асуулгын дүнгээс үзвэл, урлагийн тоглолт сэтгэлд хэр зэрэг нийцсэн талаарх асуултад 96% нь маш их сэтгэлд нийцсэн, 4% нь сэтгэлд нийцсэн, урлагийн тоглолтын бүх уран бүтээл сэтгэлд хүрсэн гэж 80% нь, бүжгийн уран бүтээл онцгой сэтгэгдэл төрүүлсэн гэж 10%, дууны уран бүтээл гэж 6%, хөгжмийн уран бүтээл гэж 4% нь хариулсан байна.

Цаашид соёл урлагаар үйлчлэх, соён гэгээрүүлэх ажилд юуг анхаарах талаар иргэдийн 70% нь саналгүй, 30% нь орон нутагт урлаг соёлын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, уран бүтээлчдийг олон нийтэд улам сайн танил болгох зэрэг саналуудыг бичсэн байна.

Тус чуулгад ямар төрөл, жанрын уран бүтээл үгүйлэгдэж байгаа талаарх асуултад 81% нь саналгүй, 19% нь орчин үеийн уран бүтээлүүдээр урын сангаа баяжуулах зэргээр санал өгсөн байна.

Өмнөговь аймгийн 65 иргэнээс авсан хэрэглэгчийн санал асуулгын дүнгээс үзэхэд, урлагийн тоглолт сэтгэлд хэр зэрэг нийцсэн талаарх асуултад 80% нь маш их сэтгэлд нийцсэн, 10% нь сэтгэлд нийцсэн, урлагийн тоглолтын бүх уран бүтээл сэтгэлд хүрсэн гэж 50% нь, бүжгийн уран бүтээл онцгой сэтгэгдэл төрүүлсэн гэж 30%, дууны уран бүтээл гэж 10%, хөгжмийн уран бүтээл гэж 10% нь хариулсан байна.

Цаашид соёл урлагаар үйлчлэх, соён гэгээрүүлэх ажилд юуг анхаарах талаар иргэдийн 50% нь саналгүй, 20% манай чуулгыг орон нутагт урлаг соёлын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, уран бүтээлчдийг олон нийтэд улам сайн танил болгох 30% хөгжим техник хэрэгсэл сайжруулах зэрэг саналуудыг бичсэн байна.

Тус чуулгад ямар төрөл, жанрын уран бүтээл үгүйлэгдэж байгаа талаарх асуултад 80% нь саналгүй, 20% нь орчин үеийн уран бүтээлүүдээр урын сангаа баяжуулах санал өгсөн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын өгсөн үүргийн дагуу 7 дугаар сарын 10-нд алба хаагчдын чөлөөт цагт зориулж, ажлын алжаалыг тайлах зорилгоор Хүй долоо худаг дахь цагдаагийн “Түр хүрээ”-нд байрлаж, үүрэг гүйцэтгэсэн 1400 алба хаагчид урлагийн бүрэн хэмжээний тоглолтыг зохион байгуулж, тоглолтын үеэр 2018 онд ажил мэргэжлийн аваргаар шалгарсан шилдэг тэргүүний 4 алба хаагчийг алдаршуулан, чуулгын дурсгалын зүйл гардуулж, алба хаагчдын дунд хөгжөөнт тэмцээн болон бүжиг явуулсан.

7 дугаар сарын 11-нд Соёл Урлагийн Их Сургууль, Монголын Урлагийн Зөвлөл, Үндэсний Их баяр наадмыг зохион байгуулах хороо хамтран Хүй долоо худаг дахь “Монгол наадам” цогцолборт зохион байгуулсан “Соёлын наадам”-д тус чуулгын уран бүтээлчид бүрэн хэмжээний тоглолтоор оролцож, 1200 гаруй гадаадын жуулчид, болон иргэдэд соёл урлагаар үйлчиллээ.

Тоглолтыг арслан.мн вэб сайт, ТВ 24, Control цахим телевиз орон даяар шууд дамжуулалт хийж, чуулгын дарга ярилцлага өгсөн болно.

Тус чуулгаас соён гэгээрүүлэх ажил, соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Хүй долоо худагт зохион байгуулсан 2 удаагийн тоглолтын талаарх 100 алба хаагч болон 79 иргэдийн үнэлгээг санал асуулгын хуудсаар авч дүнг нэгтгэж танилцав.

Түр хүрээнд зохион байгуулсан ажил нь уран бүтээлийн тоглолтоос гадна, алба хаагчдыг алдаршуулах арга хэмжээ, хөгжөөнт тэмцээн зохион байгуулахын зэрэгцээ бүжгийн үдэшлэг хэлбэрээр зохиосон нь алба хаагчдад ихээхэн таалагдсаны дээр жил бүр зохион байгуулах талаар саналаа хэлж, чуулгынхаа тоглолтыг хүлээдэг болж байна хэмээн сэтгэгдлээ илэрхийлсэн юм.

Алба хаагчдын дунд явуулсан санал асуулгын дүнгээс үзвэл, урлагийн тоглолт болон соён гэгээрүүлэх ажил сэтгэлд хэр зэрэг нийцсэн талаарх асуултад 86% нь маш их сэтгэлд нийцсэн, 11% нь сэтгэлд нийцсэн, 3% нь дунд зэрэг, урлагийн тоглолтын бүх уран бүтээл сэтгэлд хүрсэн гэж 62% нь, бүжгийн уран бүтээл онцгой сэтгэгдэл төрүүлсэн гэж 15%, дууны уран бүтээл гэж 12%, хөгжмийн уран бүтээл гэж 11% нь хариулсан байна.

Цаашид соёл урлагаар үйлчлэх, соён гэгээрүүлэх ажилд юуг анхаарах талаар алба хаагчдын 44% нь саналгүй, 56% нь анги салбарын алба хаагчдад энэ төрлийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, аялан тоглолт хийх, уран бүтээлчдийн тоог нэмэх, техник хэрэгслийг сайжруулах, үргэлжлэх цагийг уртасгах зэрэг саналуудыг бичсэн.

Тус чуулгад ямар төрөл, жанрын уран бүтээл үгүйлэгдэж байгаа талаарх асуултад 78% нь саналгүй, 14% нь залуучуудад чиглэсэн орчин үеийн уран бүтээлүүдийг баяжуулах, 8% нь алба хаагчдын дунд зохион байгуулах хөгжөөнт тоглоомыг нэмэх зэргээр санал өгсөн байна.

Иргэдээс авсан санал асуулгын дүнгээс үзвэл, 96.2% нь маш их сэтгэлд хүрсэн, 3.8% нь сэтгэлд хүрсэн гэж үнэлсэн байна.

Түүнчлэн иргэдэд зориулсан тоглолтод мэргэжлийн урлагийн байгууллагын ажилтнууд, СУИС-ын удирдлага, мэргэжлийн багш нар өндөр үнэлгээ өгч байлаа.

Тус чуулгаас ЦБҮАЖ /код 940, 947/, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх хөтөлбөр”, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2019 оны 09 дүгээр сард “Цагдаа таныг мартаагүй” хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгууллаа.

Баянгол, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн газрын Ахмадын зөвлөлийн дарга, цагдаагийн бэлтгэл хурандаа Б.Чулуунбаатар, Ц.Нацагдорж, цагдаагийн хэлтсийн төлөөлөлтэй хамтран ахмад ажилтан, цагдаагийн бэлтгэл хурандаа, ахмад дайчин Баастын Рагчаа, цагдаагийн бэлтгэл ахлах ахлагч Аюурзаны Даваажав, Төв аймгийн Угтаал цайдам сумын нутаг дэвсгэрт /130 км/ оршин сууж буй цагдаагийн ахмад ажилтан, цагдаагийн бэлтгэл хурандаа Довдонгийн Рэнцэнрээбуу нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг ЦЕГ-ын даргын баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулав.

3 удаагийн арга хэмжээнд чуулгын 96 /давхардсан тоогоор/ алба хаагчид хамрагдсан болно.

2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй алба хаагчдын чуулга уулзалт”-д чуулгын 4 эмэгтэй алба хаагч оролцож, уран бүтээлчид хэсэгчилсэн тоглолтоор үйлчилж, тухайн арга хэмжээнд цагдаагийн музейгээс албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан эмэгтэй сэргийлэгч Цэндийн Бадамханд, 2013 онд Цагдаагийн байгууллагаас БНСУ дахь НҮБ-ын мандаттай Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн анхны эмэгтэй алба хаагч, цагдаагийн ахлах ахлагч Хайдавын Эрдэнэчимэгт холбогдох материалууд, цагдаа, дотоодын цэргийн байгууллагуудын эмэгтэй алба хаагчдын гар урлалын зүйлсийг дэлгэн тавьж, цагдаагийн албаны эмэгтэй дүрэмт хувцас бүхий манеканууд, Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газрын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн ажлын танилцуулга, үзүүлэн таниулах материал, самбаруудыг байрлуулан үзэсгэлэн дэглэн танилцуулав.

Чуулгын бие бүрэлдэхүүний дунд “Дартс”-ын аварга шалгаруулах тэмцээнийг зохиож, тэмцээнд “Сүлд” баг нэгдүгээр байр, “Старс” баг хоёрдугаар байр, “Ренжерс” баг гуравдугаар байр, шилдэг тоглогчоор хөгжимчин цагдаагийн дэд ахлагч Г.Долгион тодорсон.

Алба хаагчдын эрүүл мэндийг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны эерэг таатай уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Эрүүл-Намар” явган аяллыг зохион байгуулж чуулгын 40 алба хаагч, тэдний гэр бүлийн 15 хүн хамрагдлаа.

Явган аяллын үеэр алба хаагчид болон тэдний гэр бүлийнхний дунд хөгжөөнт тоглоом, гүйлт, сумо бөхийн тэмцээн зэргийг зохиож, идэвхтэй оролцсон алба хаагчдыг урамшууллаа.

“Олон улсын ахмадын баярын өдөр”-ийг тохиолдуулан чуулгын 35 ахмад ажилтанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, ахмадуудаас залуу хойч үедээ үнэтэй сургамж, зөвлөгөө өглөө.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газраас “Урлагийн ажилтны өдөр”-ийг угтан зохион байгуулсан урлаг, спортын арга хэмжээнд чуулга бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, спортын наадмын биллъяардын тэмцээнд 2 алба хаагч оролцож, алт болон хүрэл медаль, уулын оргил булаацалдах тэмцээнд 2 алба хаагч оролцож алт, мөнгөн медаль шатар, теннисийн төрөлд 5 алба хаагч амжилттай орсон.

III улиралд биеийн тамир, спортын 4 удаагийн арга хэмжээнд чуулгын 76 алба хаагчийг хамрууллаа.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын тэмдэглэлт өдрийг тохиолдуулан чуулгын уран бүтээлчдийн бэлтгэсэн “Монгол минь амгалан байна” 40 минутын теле концертын зураг авалт болон “Үргэлж тантай хамтдаа” дууны клип, “Төрийн цагдаа” дууг үлээвэр хөгжмийн джазз аясаар бичүүлж дуусган ЦЕГ-ын ХМТ-тэй хамтран олон нийтийн 11 телевизэд өгч цацуулан, ЦЕГ-ын болон чуулгын цахим хуудсанд байршуулж, чуулгын дуучин, цагдаагийн дэд ахлагч Л.Эрдэнэболдын “Тэгш таван хүсэл” телеконцертийг 8 телевизээр гаргаж, МҮОНТВ-ийн Өглөө хөтөлбөр, Соёл-Эрдэнэ теле сэтгүүлийн зочноор 2 алба хаагч оролцож, уран бүтээл, үйл ажиллагаагаа сурталчилсан.

**Сургалтын чиглэлээр:** Тайлант хугацаанд албаны сургалтад хамрагдвал зохих 66 алба хаагч, ажилтнуудаас 4 удаагийн 6 цагийн сургалтад давхардсан тоогоор 193 алба хаагч, ажилтнууд хамрагдсан.

Тус чуулгын 16 алба хаагч Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд 08 дугаар сарын 23-наас 30-ны өдрүүдэд алба хаагчийг чадавхжуулах 3.5 кредит цагийн сургалтад амжилттай хамрагдаж, тусгайлан боловсруулсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу цагдаагийн албаны мэдлэг, ур чадвараа дээшлүүллээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2019 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу Тээврийн цагдаагийн албаны захиалгат “Олон нийтийн цагдаа бэлтгэх” сургалтад хамрагдсан 12 иргэнд “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа, иргэд олон нийтийн оролцоо” сэдэвт 2 цагийн сургалтыг соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг явуулав.

Төв архивын түүх судлалын секторын судлаач З.Мөнхзул “ЦБ-ын түүхэн замнал” сэдвээр, чуулгын соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг ЦЕГ-ын даргын 2019 оны А/196 дугаартай тушаалаар баталсан “Цагдаагийн дотоод албаны дүрэм”, “Цагдаагийн хүрээний дүрэм”, “Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм”-ээр сургалт орсон.

“Журамд өөрчлөлт оруулах, хавсралт зураг батлах тухай” ЦЕГ-ын даргын 06 сарын 24-ны А/158 тушаалаар “Дүрэмт болон ажлын хувцас, хэрэглэх журам”-д орсон өөрчлөлтийн талаар чуулгын 42 алба хаагчдыг хамруулан сургалт зохион байгууллаа.

Цагдаагийн албаны тухай хуулийн дөрөвдүгээр бүлэг /шаардлага тавих, хүний бичиг баримт шалгах, үзлэг хийх, тээврийн хэрэгсэл зогсоож шалгах, орон байр бусад газарт нэвтрэн орох, түр саатуулах, албадлага хэрэглэх гэх мэт/-д заасан хэм хэмжээ, үндэслэлийн хүрээнд цагдаагийн алба хаагчаас тодорхой ажиллагаа явуулах, албадлага хэрэглэх талаар сургалтын дүрст/видео/-г ашиглан нийт алба хаагчдад сургалт явуулсан.

Тус чуулгын удирдлага, хамт олны санаачлагаар нийт бие бүрэлдэхүүний дунд “Тамхинаас татгалзах хөдөлгөөн”-ийг эхлүүлж байгаатай холбогдуулан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн эрдэм шинжилгээний ажилтан, судлаач Б.Майцэцэг тамхины хор хөнөөл, монголчуудын болон дэлхийн нийтийн хэрэглээний өнөөгийн түвшин, тамхинаас татгалзах арга зам, ач холбогдлын талаар чуулгын 32, Дотоодын цэргийн 805 дугаар ангитай хамтран сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж эхэлсний дагуу тус ангийн 10, нийт 42 алба хаагчид сургалт зохион байгуулж, никотины хамаарлын судалгаа авч холбогдох зөвлөгөөг өгч, алба хаагчдын сонирхсон асуултад хариулт өглөө.

Түүнчлэн “Жагсаалт батлах, тушаал, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” ШШГЕГ-ын дарга, ЦЕГ-ын даргын хамтарсан 2019 оны А/123, А/159 дүгээр тушаал, ЦЕГ-ын дэд даргын 06 сарын 27-ны өдрийн 3/227 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэл, хуулийн хэлтсээс 06 сарын 27-ны өдрийн 5г/3675 тоот албан бичгээр ирүүлсэн ХЗДХ-ийн сайдын А/101 тушаалаар баталсан “Замын хөдөлгөөнийг зохицуулах, хянан шалгах журам”, Гэрч хохирогчийг хамгаалах хэлтсээс 06 сарын 27-ны өдрийн 3/227 тоот албан бичгээр ирүүлсэн мэдээлэлийг нийт бие бүрэлдэхүүнд танилцууллаа.

**Цагдаагийн музейн чиглэлээр:** Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойг угтаж, Цагдаагийн музейг орчин үеийн чиг хандлагаар хөгжүүлэх ажлын хүрээнд доктор, профессор А.Энхбаяр эрхлэгчтэй МУИС-ийн харьяа Компьютер график,

мультимедиа судалгааны лабораторитай хамтран орчин үеийн технологид суурилсан дараах төслүүдийг хэрэгжүүлэхээр төслийн танилцуулга, төслийн санхүүжилтийн зардлын 84.500.000 төгрөгийн тооцоо судалгааг чуулгын даргад танилцуулсан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас “Музейн хөгжил - 2019” чуулган зохион байгуулж, музей, соён гэгээрүүлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн оролцлоо.

**Уран бүтээлийн чиглэлээр:** Чуулгын урын санг баяжуулах ажлын хүрээнд уран сайхны зөвлөлөөс уран бүтээлчдэд өгсөн даалгаврыг анги тус бүрээр чуулгын дарга тэргүүтэй уран сайхны зөвлөл үзэж, биелэлтийг шалгахад 7 дуучны 11 уран бүтээлийн 5 дуу шаардлага хангаж, бүжиг ангийн 6 гоцлол бүжгийн уран бүтээлээс 2 бүжгийг урын санд нийлүүлэх, хөгжим ангийн дан хөгжмийн зохиол 2, цөөхүүл хөгжмийн бүтээл 3, “Ялалтаар цэлмэсэн тэнгэр” маршийн зохиолуудыг урын санд оруулахаар шалгаруулж цаашид тоглолтуудад нийлүүлж ажиллах боломжтой үнэлгээг өгсөн байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас ирүүлсэн 42 хүсэлтийн дагуу уран бүтээлээр үйлчиллээ.

Томоохон арга хэмжээнээс дурьдвал “Дэлхийн хар тамхи, мансууралтай тэмцэх ОУ-ын өдөр”, ДХИС-ийн үйл ажиллагаатай танилцсан БНТУ-ын цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн албаны дэд дарга тэргүүтэй төлөөлөгчид, Турк улсын Үндэсний цагдаагийн академийн багш нарт зориулсан арга хэмжээ, Мөрдөн байцаах алба, Тээврийн цагдаагийн албаны эхний хагас жилийн тайлангийн хурал, Эрэлч нохойн албаны түүхт 75 жилийн ойн хүрээнд зохиогдсон “Герман хоньч нохойн аварга шалгаруулах тэмцээн”, НХЖХОНАБХА, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн I,III хэлтсийн алба хаагчдын “Тангараг өргөх ёслолын ажиллагаа”, Тулгар төрийн 2228, Их Монгол улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ойг тохиолдуулан ЦДЦ-ын байгууллагын шагнал гардуулах ёслолын арга хэмжээнүүд, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн III хэлтсийн 5 жилийн ой, ЭЦА-ны ойн баярын хүндэтгэлийн хүлээн авалт, Харилцаа холбооны салбар үүсч хөгжсөний 98 жилийн ойн арга хэмжээ, “Эрэлч нохойн алба” үүсгэн байгуулагдсаны 75 жилийн ойн арга хэмжээ, Прокурорын албаны өдөр”, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын түүхт ой, Мөрдөн байцаах албаны “Мөрдөгч 2019” тэмцээн, хамтын ажиллагаатай байгууллагуудаас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу Дотоод Хэргийн Их сургуулийн 2019-2020 оны хичээлийн шинэ жилийн нээлт, Монголын үндэсний радиогийн түүхт 85 жилийн ойн баярын хурал, Монголын Үндэсний Төв музейн арга хэмжээ, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, “Бамбай” хамгаалалтын албаны 20 жилийн ой, Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан Киокушинкай каратэгийн улсын аврага шалгаруулах тэмцээн, ХЗДХЯ-ны “Нээлттэй өдөр”, МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй алба хаагчдын чуулга уулзалт”-ын хүндэтгэлийн тоглолт зэрэг үйл ажиллагаанд давхардсан тоогоор 5000 гаруй алба хаагч, 14500 гаруй иргэнд уран бүтээлээр үйлчилсэн байна.

Чуулгаас зохион байгуулдаг томоохон хэлбэрийн урлагийн тоглолт болон бусад уран бүтээлийн чиглэлийн ажилд байнга дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг адил, төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдлагад талархал ирэлхийлж ЦЕГ-ын даргын тушаалаар ЦДБЭЧ-ын дарга, ерөнхий менежер, хурандаа Г.Золзаяаг “Дотоодын цэргийн алдар” медалиар, уран сайхны удирдаач, ахмад Л.Баттөрийг “Цагдаагийн төлөө” медалиар шагнаж, чуулгын даргын зөвлөлийн гишүүд гардуулан өгсөн.

БНСУ-ын Олон улсын урлаг, соёлын тоглолт солилцооны холбооноос зохион байгуулсан Солонгос-Монгол 2 улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 29 жилийн ойг угтсан “Солонгосын соёлын өдөр-2019” арга хэмжээнд чуулгын үлээвэр хөгжим оролцож, тус байгууллагаас лимбэ 1, кларнет 1, труба 1, тромбон 1, нийт 4 ширхэг хөгжмийн зэмсгийг бэлэглэлээ.

Улаанбаатар хот болон Сөүл хотын хамтран зохион байгуулсан “2019 бүжгийн фестивал”-д чуулгын эрэгтэй бүжигчид бүжгийн багш, бүжиг дэглээч МУСТА, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгарын дэглэлт “Товшуурт торгууд” бүжгээр “Гуравдугаар байр” эзлэв.

Бүжгийн багш, бүжиг дэглээч, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгар БНСУ-ын Бусан хотноо зохион байгуулагдсан Олон улсын гоцлол бүжигчдийн II уралдааны этник бүжгийн төрөлд мөнгөн медаль хүртэв.

Азийн соёлын солилцооны хүрээнд зарлагдсан “Соёлын хамтрагч” тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн сертификат олгох БНСУ-ын Сөүл хотноо “Trust” бүжгийн компанийн модерн бүжгийн 5 сарын сургалтад хамрагдаж байна.

### **Гурав. Санхүү, бүртгэл, санхүү хангамж, үйлчилгээ, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах талаар**

2020 оны төсвийн төсөөллийг боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын СААА-д очиж төсвийг хамгаалав. 2019-2020 оны төсвийн тооцооны зардлын шилжүүлгийн төслийг хийсэн.

Чуулгын 2019 оны эхний хагас жилийн тооллогыг алба хаагч, ажилтан болон эд хариуцагч нарын эд хөрөнгө, бараа материалыг тоолох тооллогын ажлын дагуу хөгжим, дуу ангийн эд хөрөнгүүдийг тоолж, байгууллагын 2019 оны эхний хагас жилийн тайлан балансыг гаргаж ЦЕГ-ын СААА-д шалгуулсан.

Алба хаагчид, ажилчдын 2019 оны ээлжийн амралтын хуваарийн дагуу 08 дугаар сард амрах 47 алба хаагч, ажилтны ээлжийн амралтын хуудсыг бичиж, цалин, амралтын мөнгийг бодож олгов.

Байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу засвар үйлчилгээний ажлуудыг хийж, чуулгын уулзалтын өрөөний коридорын босгыг намсган, тэгшитгэж, 1 давхарын зүүн талын коридорын таазанд эмульс хийсэн.

Мөн урлагийн их танхимын зүүн хэсгийн шалыг PVC шал суулгаж, яамны дотор болон нүүрэн талыг будаж засварласан.

Чуулгын албан хэрэгцээнд бичиг хэргийн болон аж ахуйн материалыг татаж, өдөр тутмын орлого, зарлага, дансны бичилтийг хийж ажилласан болно.

Чуулгын дундын сангаас 08 дугаар сар, 09 дүгээр сарын 15-ны байдлаар төрсөн өдрийн баяр тохиосон 7 алба хаагч, эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн 2 алба хаагч, ОУ-ын уралдаанд оролцсон 1 алба хаагчид журамд заасны дагуу дурсгалын зүйл болон мөнгөн дэмжлэгийг үзүүлсэн.

2019 оны 4 дүгээр сард зохион байгуулсан “Хачин Гоё” нэгдсэн тоглолтын орлогоос 35.065.000 төгрөгийг харьяа байгууллага, бусад байгууллага болон алба хаагчдаас цуглуулж орлогыг төвлөрүүлсэн.

2019 оны 09-р сарын 17-ны байдлаар тус чуулгад улсын төсвөөс 499,4 сая төгрөгний төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 499,4 сая төгрөг, өөрийн орлогоос 14,4 сая төгрөг орж бүгд 515,6 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэртэй ажиллалаа.



Тус чуулгын 68 алба хаагчдын цалин хөлсийг батлагдсан орон тооны цалингийн сүлжээний дагуу цалингийн /Payrol/ программаар сар бүрийн 10 , 25-нд бодож цалингийн тооцооны нэг бүрчилсэн баримтыг программаас хэвлэн авч олгож байна.

Шилэн дансны мэдээллийн сар бүрийн 8 ны өдөрт багтаан нийт 16 маягтын дагуу тайланг оруулан цахимд хуудсанд байршуулсан. 9 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор нийт 99 мэдээллийг оруулсан.

### **Дөрөв. Алба хаагчдын сахилга хариуцлага, манлайллыг дээшлүүлэх талаар**

Чуулгын 7,8,9 дүгээр сарын жижүүрийн алба хаагчдын томилгоог хийж батлуулан жижүүрийн алба хаагчдад иргэдтэй зөв боловсон харьцах, үүрэг гүйцэтгэхдээ сонор сэрэмжтэй байж, Цагдаагийн албаны тухай хууль, дүрэм, журмуудыг мөрдөж ажиллах талаар үүрэг чиглэлийг өгч, алба хаагчдын цагийн бүртгэлийг хөтөлж өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

Алба хаагчдын 2 дугаар улирлын цагийн тооцоог нэгтгэн гаргаж хэсгүүдийн сахилга хариуцлагын зөвлөгөөн дээр танилцуулж, ажлын цаг ашиглат, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цагдаагийн алба хаагчийн ёс зүй, сахилгын дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар үүрэг, чиглэл өгөв.

Алба хаагчдын ээлжийн амралтыг олгосонтой холбогдуулж нийт 47 алба хаагчаас ээлжийн амралтыг зөв зохистой өнгөрүүлэх талаар баталгаа гаргуулж, гарын үсэг зуруулж авсан.

9 дүгээр сарын 02-ны өдөр бие бүрэлдэхүүний дунд албаны дүрэмт хувцас, жагсаалын үзлэг явуулж 47 алба хаагч оролцохоос 31 алба хаагч оролцлоо.

Түүнчлэн Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ аймгийн Мандал сум, Төв аймагт томилолтоор ажиллахдаа сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх талаар алба хаагчдаас баталгаа авч, алба хаагчдын хаягийн бүртгэлийг шинэчилсэн.

Чуулгын жижүүрийн цагдаа нарт үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор 14 чиглэлээр үүргийг бичгээр өгч биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Офицерын бүрэлдэхүүнд оруулах санал хүргүүлсэн 3 алба хаагчийн ХАСХОМ-ын урьдчилсан мэдүүлгийг цахимаар бөглүүлж Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх зэргээр ажилласан болохыг танилцуулья.

“СҮЛД” ЧУУЛГА